



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022.06.30 № А-1/1378
танай _____-ны № _____-т

Ногдол ашиг төвлөрүүлэх тухай

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолоор баталсан.

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг 2,579,840,000 төгрөг байхаар тогтоосон болно.

Иймд төрийн өмчид ногдох ногдол ашгийг Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын ногдол ашгийн 100900000702 тоот дансанд төвлөрүүлж, гүйцэтгэлийг ирүүлэхийг мэдэгдье.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоолыг хавсаргав.

Хавсралт *2* хуудастай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



132008468



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны Улсын төсөв болон ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг нэгдүгээр, Ашигт малтмалын ордны тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хэмжээг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус тогтоосугай.


2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс(Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ЦЭВЭР АШГИЙН ДҮНГЭЭС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Нэр	2021 оны цэвэр ашгийн дүн /сая.төгрөг/	Төрийн өмчийн ногдол ашиг /сая.төгрөг/
1	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	6,449.6	2,579.84